



# ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

## “Авто замын сангийн хөрөнгийн 2016 оны зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУАГ-НАБ/2017/02-ГА



**Авто замын сангийн төсвийг дутуу бүрдүүлсэн боловч сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулжээ.**



Мандалговь  
2017 он

## АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үндсэн мэдээлэл	4-5
Дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг	<b>Бүлэг 1. Авто замын сангийн төсвийг 33.0 сая төгрөгөөр дутуу бүрдүүлжээ.</b>	
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Авто замын сангийн орлогыг дутуу төлөвлөж, ИТХ сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлаагүй байна.	6-7
Ахлах аудитор Д.Ихбаяр	1.2 Авто замын тухай хуульд заасан эх үүсвэрийн 14.2 хувь буюу 33.0 сая төгрөгийг Авто замын санд төвлөрүүлээгүй байна.	7-8
Аудитор Т.Оюун-Эрдэнэ	Бүлэг 2 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тодорхой үр дүн гарсан байна. 2.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна.	8-9
<b>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу.</b>	2.2. Зарим ажлыг хэрэгжих боломжгүй цаг хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн нь тендер шалгаруулалтын аргыг буруу сонгоход хүргэсэн байна.	9-12
Уг тайланг УАГ-ын вэб сайтаас үзнэ үү.  <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	2.3. “Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил”-ын хяналтын төсөвт тусгагдаагүй боловч, технологийн дагуу зайлшгүй хийгдсэн ажлыг гэрээнд нэмэлтээр тусгаагүй байна.	12-14
Хаяг: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар	2.4. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, төсөл арга хэмжээ нь зорилтот үр дүндээ хүрчээ.	14-16
<b>2017 оны 07 дугаар сар</b>	Бүлэг 3 Авто замын сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, зарим ажлын захилагчийн хяналт хангалтгүй байна. 3.1 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.	16-17
	3.2 Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн оруулж, олон нийтэд мэдээлсэн байна.	17-18
	Дүгнэлт	18
	Зөвлөмж	19
	Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар	20
	Аудитын газрын тайлбар	21
	Тайлан баталгаажуулах тушаал	22-25
	Тайлангийн хавсралтууд	26-29

**ТОВЧИЛСОН ҮГС**

ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГ	Засгийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл, арга хэмжээ
М <sup>3</sup>	Метр куб
М <sup>2</sup>	Метр квадрат
ТХДЖТ	Төв халхын дуулалт жүжгийн театр
ХОХБТ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт
БХБ	Барилга хот байгуулалт
СТС	Санхүү төрийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаал, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:** Авто замын нийт хөрөнгийн бүрдүүлэлт, цаашид байгуулсан эсэхэд хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналтыг гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, үндэслэл, зорилт, зорилтын дагуу хяналтын үр дүнд хяналт үр нөлөөтэй эсэх.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрэн бүрдүүлж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх;
- Дотоод хяналт үр нөлөөтэй эсэх.

**Аудитын хамрах хүрээ:** Аудитаар сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын байдал, Авто замын сангаас 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн байгууламж болон зам засварын ажлын ашиглалт, хадгалалт хамгаалалттай танилцаж, бусад холбогдох баримт материал, бүртгэл тайлан мэдээг хамруулав.

**Аудитын арга зүй:** Аудитыг үндэслэл, зорилт, зорилтын дагуу хяналтын үр дүнд хяналт үр нөлөөтэй эсэх, тулгуур зарчим (АДБОУС 300), гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ыг ашиглан, Гүйцэтгэлийн аудитын журам, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын арга зүйн дагуу аймгийн ЗДТГ, Гурвансайхан сумын ЗДТГ-ын өмчлөлийн хөрөнгө оруулалт болон санхүүгийн баримт материалыг түүвэрлэн шалгах, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, үндэслэл, зорилт, зорилтын дагуу хяналтын үр дүнд хяналт үр нөлөөтэй эсэх, ажиглалт хийх, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг шаардлагатай горимуудыг хэрэгжүүлэн, цуглуулсан нотлох баримтад тулгуурлан судалгаа шинжилгээ хийж дүнг нэгтгэн, түүнд үндэслэн хяналтын үр дүнд хяналт үр нөлөөтэй эсэх, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт :** Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;

- Авто замын тухай хууль;
- Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоол;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- $\text{Áóñàà } \text{õì } \text{ëáí } \text{äáí } \text{õ } \text{ýðõ } \text{ç¿éí } \text{àèòóóä.}$

**Аудит хийсэн бүрэлдэхүүн, хугацаа :** Аудитыг тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, нийцлийн багийн ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Т.Оюун-Эрдэнэ нар 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн 7 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын дүн, тайлан баталгаажуулалт:** Аудитын явцад нийт 274.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 94.5 сая төгрөгийн  $\text{ç}^0 \text{ ð-ëèèé}$ г давтан гаргахгүй ажиллах хугацаатай албан шаардлага хүргүүлж, 179.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө.

#### Үндсэн мэдээлэл:

Аймгийн Авто замын сангийн үйл ажиллагааг 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан Авто замын тухай хууль, 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" зэрэг эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Хуулийн дагуу 1998 онд улсын Авто замын сан, 1998-2000 онуудад нийслэл, аймгуудад орон нутгийн Авто замын сангууд тус тус байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Авто замын сан нь аймгийн Засаг даргын мэдэлд байгаа бөгөөд сангийн хөрөнгийг тухайн аймгийн орон нутгийн чанартай зам, замын байгууламжийг барих, засварлах арчлах, хамгаалах тохижуулах, мэргэжлийн хяналт тавихтай холбогдон гарах арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн авто замын сангийн орлого нь АТБӨЯХ-ийн татвар, зам ашигласны төлбөр, улс орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө болон зээл хандив тусламжийн орлогоос бүрддэг бөгөөд 2016 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Авто замын санд 228.5 сая төгрөгийг хуваарилж, гүйцэтгэлээр 178.0 сая төгрөгийг зарцуулж 50.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

## **БҮЛЭГ 1. АВТО ЗАМЫН САНГИЙН ТӨСВИЙГ 33.0 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ БҮРДҮҮЛЖЭЭ.**

### **1.1 Авто замын сангийн орлогыг дутуу төлөвлөж, ИТХ сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлаагүй байна.**

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.14<sup>1</sup>-д заасны дагуу 2016 онд авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 141 дүгээр захирамжаар баталсан байна. Үүнд:

- Хүүхдийн паркийн авто замын дагуух явган хүний зам;
- Прокурорын гадна талбайн тохижилт;
- Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилт.

Дээрх ажлуудыг хийхээр баталсан боловч аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/355 дугаар захирамжаар 141 дүгээр захирамжийг хүчингүй болгож дараах ажлын жагсаалтыг баталсан байна. Үүнд:

- Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв,
- Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил;
- Буянт гүүр, Найрамдал, Зоо, Айргийн гудамжны авто замын засварын ажил;
- Буяан нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжны авто замын засварын ажил.

Авто замын сангийн 2016 оны төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах байдлаар баталжээ.

- 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Дундговь аймгийн 2016 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолоор замын санд 183.7 сая төгрөг, жолоочийн хариуцлагын даатгалд 16.4 сая төгрөгийг,
- 2016 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “2016 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 10 дугаар тогтоолоор замын санг өмнөх оны үлдэгдлээс 44.9 сая төгрөгөөр нэмж, 228.5 сая төгрөг болгон тодотгон баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засгийн газрын 1998 оны “Журам батлах тухай” 149 дүгээр тогтоолын 1.8<sup>2</sup> дахь заалтын дагуу сангийн нийт төсвийг баталсан боловч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт болон ажил тус бүрийн төсвийг батлаагүй байна.

Төсөв батлах үед Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний зураг төсөв нь тодорхойгүй байсан гэдэг шалтгаанаар ИТХ жагсаалтыг батлаагүй байна.

Авто замын тухай хуульд АТБӨЯХ-ийн албан татвар, орон нутгийн зам ашигласны хураамжийг замын санд төвлөрүүлэхээр заасан боловч зөвхөн

<sup>1</sup> Аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгоно

<sup>2</sup> Улсын замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, зарцуулах хөрөнгийн хэмжээг Засгийн газар, орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус батална

АТБӨЯХ-ийн албан татварын орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн нь сангийн эх үүсвэрийг дутуу төлөвлөхөд хүргэжээ.

Сангийн эх үүсвэрийг АТБӨЯХ-ийн албан татвар болон авто замын хураамжийн орлогоос сүүлийн 3 жилийн байдлаар дараах байдлаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт №1

Он	Татварын орлогын төлөвлөгөө			Сангийн батлагдсан төсөв			Зөрүү
	АТБӨЯХ-ийн албан татвар	Авто замын хураамж	Нийт	Авто замын сан	Жолоочийн хариуцлагын даатгал	Нийт	
2014	232.0	27.5	259.5	220.3	23.2	243.5	16.0
2015	181.3	31.5	212.8	197.4	15.5	212.9	-0.1
2016	200.0	35.0	235.0	228.5	16.4	244.9	-9.9

2014 онд хуульд заасан эх үүсвэрээс 16.0 сая төгрөгөөр дутуу, 2015 онд 0.1 сая төгрөгөөр, 2016 онд 9.9 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Улсын дугаартай тээврийн хэрэгслийн татвар хураамж улсын төсөвт төвлөрдөг болсонтой холбоотойгоор авто замын хураамжийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөхгүй бол орлого тасрах эрсдэлийг үүсгэж байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4. /авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь/ мөн 22.1.2 /жолоочийн даатгалын тухай хууль зөрчсөн буруутай этгээдэд ногдуулсан торгуулийн орлогын 50%/ -д заасан орлогыг Авто замын тухай хуулийн 21.2-д заасны дагуу албан журмын даатгагчдын холбооны дансанд төвлөрүүлэх ёстой. 2016 оны АТБӨЯХ-ийн албан татварын суурь орлогыг 163.5 сая төгрөгөөр тооцож, түүний 10 хувь буюу 16.4 сая төгрөгөөр баталжээ.

## 1.2 Авто замын тухай хуульд заасан эх үүсвэрийн 14.2 хувь буюу 33.0 сая төгрөгийг Авто замын санд төвлөрүүлээгүй байна.

Авто замын тухай хуульд заасны дагуу “Авто замыг байнга ашигласны төлбөр авах журам, төлбөрийн хэмжээ”-г аймгийн Засаг даргын 2012 оны А/72 дугаар захирамжаар баталжээ.

2016 онд АТБӨЯХ-ийн албан татварын төлөвлөгөө 200.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 204.9 сая төгрөг буюу 2.5 хувиар давж биелсэн. Харин авто замын хураамжийн төлөвлөгөө 35.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 28.1 сая төгрөг буюу 19.7 хувиар тасарчээ. Энэ нь улсын дугаартай тээврийн хэрэгслийн татвар хураамж улсын төсөвт төвлөрдөг болсонтой холбоотой байна.

Тус онд авто замын санд 200.0 сая төгрөгийг АТБӨЯХ-ийн албан татварын орлогоос, 44.9 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс тодотгон, нийт 244.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Сүүлийн 3 жилийн байдлаар албан татвар, хураамжийн орлогоос авто замын сан болон жолоочийн хариуцлагын даатгалыг дараах байдлаар санхүүжүүлсэн байна. Хүснэгт №2

Он	Татварын орлого, сангийн эх үүсвэрийн харьцуулалт						Зөрүү
	АТБӨЯХ-ийн албан татвар	Автозамын хураамж	Нийт	Авто замын сан	Жолоочийн хариуцлагын даатгал	Нийт	
2014	237.3	32.9	270.2	220.3	23.2	243.5	26.7
2015	182.2	25.4	207.6	197.4	15.5	212.9	-5.3
2016	204.9	28.1	233	228.5	16.4	244.9	-11.9

Авто замын сангийн гүйцэтгэл нь 2014 онд албан татвар, хураамжийн орлогоос 26.7 сая төгрөгөөр бага, 2015 болон 2016 онуудад 5.3 сая төгрөг, 11.9 сая төгрөгөөр тус тус илүү санхүүжүүлжээ. Хүснэгт №2

2015 оноос гүйцэтгэл бага харагдаж байгаа нь эдийн засгийн хүндрэлтэй байдал, хэмнэлтийн горимд шилжин ажилласантай холбоотой байна.

Авто замын тухай хуульд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас орон нутгийн замын санд үлдээх хувь, хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан боловч ЗГ-ын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-д хувь хэмжээг зааж өгөөгүй байна.

АТБӨЯХ-ийн албан татвараас орон нутгийн замын санд үлдээх хувь, хэмжээг Засгийн газар тогтоогоогүйгээс тус онд хуульд заасан эх үүсвэрээс 233.0 сая төгрөгийг бүрдүүлж, авто замын санд 200.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 33.0 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд үлдээсэн байна.

## **БҮЛЭГ 2. САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, ТОДОРХОЙ ҮР ДҮН ГАРСАН БАЙНА.**

### **2.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна.**

Дундговь аймгийн хэмжээнд 2016 онд замын сангийн хөрөнгөөр дараах ажлуудыг гүйцэтгэжээ.

Үүнд:

1. Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажилд 4.2 сая төгрөг,
2. Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажилд 79,3 сая төгрөг,
3. Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажилд 53.1 сая төгрөг,



4. Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажилд 41.4 сая төгрөг,

Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5<sup>3</sup> дахь заалтаар тодорхойлсон зорилго зорилттой нийцэж байна.

## 2.2. Зарим ажлыг хэрэгжих боломжгүй цаг хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн нь тендер шалгаруулалтын аргыг буруу сонгоход хүргэсэн байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийг аймгийн ЗДТГ-ын тушаал, сумын Засаг даргын захирамжаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.4<sup>4</sup> -д заасны дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангуулж ажилласан байна.

Аймаг, сумаас зохион байгуулсан тендерийн үнэлгээний хороонд АЗ сертификаттай эрх бүхий хүмүүс ажиллажээ.

Авто замын сангийн 2016 оны худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1<sup>5</sup>, 8.2-т заасны дагуу 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс бүрэн зохион байгуулж, бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд хууль журмыг мөрдөж ажиллажээ.

Тайлант онд зохион байгуулсан тендер шалгаруулалтыг ЗГ-ын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг үндэслэн 3 ТАХ-г харьцуулалтын аргаар, 1 ТАХ-г шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулжээ. /Хавсралт 1 болон хүснэгт № 3 /

Хүснэгт №3

№	Гүйцэтгэсэн ажил	Нийт өртөг	Тендер шалгаруулсан арга			
			Нээлтэй	Хязгаарлагдмал	Харьцуулалт	Шууд гэрээ
1	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажил	41.4			41.4	
2	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил	53.1			53.1	
3	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил	79.3			79.3	

<sup>3</sup> Орон нутгийн авто замын санг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, тохижуулах, мэргэжлийн хяналт тавихтай холбогдон гарах арга хэмжээ санхүүжүүлэхэд зарцуулна

<sup>4</sup> Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна

<sup>5</sup> Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно:

4	Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил	6.0				6.0
	<b>Дүн</b>	<b>179.8</b>			<b>173.8</b>	<b>6.0</b>

Харьцуулалтын аргаар зарласан 3 тендерийн хувьд хуульд зааснаар 3-аас доошгүй этгээдэд үнийн санал ирүүлэх урилга хүргүүлжээ.

Тендерийн баримт материал болон дээрх судалгаанаас харахад аймгийн төвд хийгдсэн нийт 94.5 сая төгрөгийн авто зам засварын ажлыг байршлаар нь 2 хэсэг болгон хувааж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй, харьцуулалтын аргыг сонгон, тендер шалгаруулалт явуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн, 8.1<sup>6</sup>, 8.4<sup>7</sup>, 8.5<sup>8</sup>, 33 дугаар зүйлийн 33.1<sup>9</sup>, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4<sup>10</sup>, 24 дүгээр зүйлийн 24.4<sup>11</sup> дэх заалтуудад нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлжээ.

Тус ажлын тендер шалгаруулалтад харьцуулалтын аргыг хэрэглэсэн нь тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой, орон нутагт ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын өрсөлдөөнийг хязгаарлаж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6<sup>12</sup>, 11.2<sup>13</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна.

Захиалагч тал /аймгийн ЗДТГ/ Төсвийн тухай хууль болон ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин тендер шалгаруулалтын аргыг буруу сонгосон нь сангийн хөрөнгөөр хийх төсөл арга хэмжээг зохион байгуулалтгүй, хэрэгжих боломжгүй цаг хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөснөөс шалтгаалжээ.

<sup>6</sup> Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно.

<sup>7</sup> Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

<sup>8</sup> Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

<sup>9</sup> Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.

<sup>10</sup> Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох

<sup>11</sup> Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно

<sup>12</sup> Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно.

<sup>13</sup> Захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авахыг хориглоно.

Цаашид сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48<sup>14</sup> дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" -ыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Энэ асуудалд төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36<sup>15</sup> дахь заалт, Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан "Авто замын санг төлөвлөх түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 8<sup>16</sup> дахь заалтын дагуу хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2016 онд аймгийн төвд харьцуулалтын аргаар тендер нь зарлагдсан нийт 94.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний тендер шалгаруулалтад 8 оролцогч материалаа ирүүлснээс тендерийн баримт бичигт тавьсан шаардлагыг хангаагүй 7 оролцогчийн тендерээс татгалзсан байна.

Мөн харьцуулалтын аргаар зарлагдсан 79.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил" –ын тендерийн ажлыг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргын 2016 оны 05 сарын 17-ны өдрийн А/185 тоот захирамжаар Гурвансайхан сумын Засаг даргад шилжүүлж, шалгаруулалтад 3 оролцогч материалаа ирүүлснээс тендерийн баримт бичигт тавьсан шаардлагыг хангаагүй 2 оролцогчийн тендерээс татгалзсан байна.

Шалгуур хангасан тендерүүдээс үнийн саналаар эрэмбэлэн хамгийн бага үнийн санал ирүүлсэн тендерт оролцогчтой гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэжээ.

Аудитаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хугацааг хууль, журамд нийцсэн эсэхийг судалж үзэхэд үнийн санал ирүүлэх хугацаа 8-10 хоног, бага үнийн санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон хугацаа 3-8 хоног буюу нийт 11-18 хоногт багтаан зохион байгуулжээ.

## Хүснэгт №4

№	Төсөл, арга хэмжээний нэр	Үнийн санал ирүүлэх мэдэгдэл өгсөн огноо	Үнийн санал ирүүлэх огноо	Үнийн санал ирүүлэх хоног	Хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчийг шалгаруулсан	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон хугацаа
---	---------------------------	--	---------------------------	---------------------------	--	-----------------------------------	---

<sup>14</sup> Худалдан авах ажиллагааг төлөвлөх

<sup>15</sup> төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

<sup>16</sup> Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга хянаж санхүүжүүлнэ.

1	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гу дамжийн авто замын засварын ажил	2016.09.29	2016.10.06	8	2016.10.07	2016.10.10	3
2	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил	2016.09.29	2016.10.06	8	2016.10.07	2016.10.10	3
3	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил	2016.06.06	2016.06.16	10	2016.06.16	2016.06.23	8

Судалгаанаас харахад харьцуулалтын аргаар тендерт оролцогчийг шалгаруулах, гэрээ байгуулах эрх олгохдоо ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.2<sup>17</sup>, 33.3<sup>18</sup> дахь заалтын дагуу зохион байгуулсан байна.

**2.3. “Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил”-ын хяналтын төсөвт тусгагдаагүй боловч технологийн дагуу зайлшгүй хийгдсэн ажлыг гэрээнд нэмэлтээр тусгаагүй байна.**

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 3 төсөл, арга хэмжээг Иргэний хуулийн дагуу гэрээ байгуулах тухай захиалагчийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэгчтэй “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” гэрээг байгуулсан байна.

Харин “Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил”-ын гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан гэх боловч аудитын явцад гэрээг ирүүлээгүй бөгөөд тус ажилд 4.2 сая төгрөг зарцуулж, зураг төсвийг хүлээж аваагүй, гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгэсэн эсэхийг шалгах боломжгүй байлаа.

Аудитын явцад Аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэс дээрх асуудалд дараах тайлбарыг өгсөн.

“Хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан мэргэжилтний ажил хүлээлцэх явцад өмнө нь ажил хариуцаж байсан мэргэжилтэн 2016 оны авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил”-ын гэрээг хүлээлгэн өгөөгүй тул ажлын гэрээ олдохгүй байна.”

Аймгийн төвийн авто зам засварын ажлыг гүйцэтгэгч байгууллага гэрээнд заагдсан хугацаанд бүрэн хийж, хүлээн авсан акт үйлдсэн байна.

Гурвансайхан суманд хийгдсэн “Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил”-ын хувьд батлагдсан төсөвт 3153 м<sup>2</sup> ажлыг гүйцэтгэх байсан

17 Харьцуулалтын аргыг дараахь байдлаар хэрэглэнэ: 33.2.1.техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх; 33.2.2.техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох.

18 Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.

боловч аудитын явцад хийсэн хэмжилтээр 2694 м<sup>2</sup> ажил гүйцэтгэж, 459 м<sup>2</sup> дутуу хийсэн байна. Энэ талаар тодруулахад хяналтын төсөвт ороогүй нэмэлт ажлыг сумын Засаг даргатай харилцан тохирч 6.7 сая төгрөгөөр хийсэнтэй холбоотойгоор ажлын талбайг хасч, төсөвт нь тааруулж хийж гүйцэтгэсэн гэсэн тайлбарыг гүйцэтгэгч байгууллагын инженер өглөө.

Гүйцэтгэгч байгууллага хяналтын төсөвт тусгагдаагүй, технологийн дагуу зайлшгүй хийгдсэн ажлын гүйцэтгэлийг гарган баталгаажуулж, зардлыг санхүүжүүлэх акт үйлдсэн боловч ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулах, нэмэлт ажил гүйцэтгэх талаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байв.

Тус ажлыг хүлээн авах комисс “Явган хүний зам, авто зогсоол нь зураг төсвийн дагуу бүрэн хийгдэж, зориулалтаар ашиглахад хангалттай” гэж дүгнэн ажлыг хүлээн авч, акт үйлдэн ашиглалтад оруулжээ.

Гэвч комиссын гишүүд тус ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж, нэмэлт ажил хийсэн талаар ямарч мэдээлэлгүй байсан нь комиссын бүрэлдэхүүнд тухайн салбарын талаар мэдлэг туршлагатай, мэргэжлийн зүгээс хяналт тавих төлөөллийг оролцуулаагүйтэй холбоотой байна.

Цаашид захиалагч барилга байгууламж шинээр ашиглалтад оруулах комисс томилохдоо Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.3<sup>19</sup>-д заасны дагуу байгуулж, журмын 4.12.3.3<sup>20</sup>-дахь заалтыг мөрдүүлж ажлыг хүлээн авч ашиглалтад оруулж байх шаардлагатай байна.

Гурвансайхан суманд хийгдсэн Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажлын хувьд тус ажлыг гүйцэтгэгч “Баянгийн говь” ХХК-иас “Ажлын явц 90 хувьтай байхад урьдчилгаа болон гүйцэтгэлийн санхүүжилт хийгдээгүй байна.

Санхүүжилт хийгдсэн үед ажлыг дуусгах, эсвэл гэрээний хугацааг сунгах шаардлагатай боллоо.” гэсэн хүсэлт ирүүлснийг үндэслэн гэрээг 49 хоногоор сунгажээ. Хавсралт 4 –т харуулав.

Сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагууд магадалшгүй ажлын зардлаар хийж гүйцэтгэсэн ажлуудыг хүснэгт № 6, Хавсралт 3-т харуулав.

Хүснэгт № 6

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч байгууллага	Магадалшгүй ажлын зардал /сая төгрөг /	Магадалшгүй ажлын зардлаар хийгдсэн ажил
-----	---------------------------	------------------------	--	--

<sup>19</sup> Барилга байгууламжийн зориулалт, онцлогоос хамааруулан тухайн барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, техник технологитой нь холбоотой салбарын төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг комиссын бүрэлдэхүүнд оруулна

<sup>20</sup> Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээний ажил нь зураг төсөл, барилга техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, галын норм, дүрэм, стандартын шаардлагыг хангасан эсэхийг нарийвчлан шалгаж, үнэлэлт дүгнэлт гаргана.

1	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажил	"Бумбат даваа" ХХК	0.7	Авто замын 4 хэсэг дээр зураг, төсөвт ороогүй болон зураг хийгдсэнээс хойш эвдэрсэн 35.2 м2 замын цоорхойг нөхөх ажлыг хийсэн байна.
2	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил	"Бумбат даваа" ХХК	0.9	Авто замын 2 хэсэг дээр, зураг, төсөвт ороогүй болон зураг хийгдсэнээс хойш эвдэрсэн 45.4 м <sup>2</sup> замын цоорхойг нөхөх ажлыг хийсэн байна.
3	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил	"Баянгийн говь" ХХК	1.4	100 м <sup>3</sup> замын хашлагыг цемент болон бетонон хольцоор хийсэн байна.
	<b>Дүн</b>	-	<b>3.0</b>	

Аймгийн төвийн зам засварын ажлыг Хот тохижилт үйлчилгээний албаны үндсэн хөрөнгийн дансанд барилга байгууламжийн сайжруулалтаар, Их газрын чулууны ууланд тавигдсан авто машины зогсоол, явган хүний зам талбайг аймгийн ТХДЖТ-ын үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэсэн байна.

#### 2.4. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, төсөл арга хэмжээ нь зорилтот үр дүндээ хүрчээ.

Аймгийн төвийн авто замын сангийн засварын ажлыг "Тэрмэн зам" ХХК-ний боловсруулсан зураг, төсвийн дагуу "Бумбат даваа" ХХК гүйцэтгэсэн байна.

Аудитын явцад холбогдох мэргэжилтнүүдийг байлцуулан зам засварын ажлын гүйцэтгэлийг зурагт заагдсан газруудад очиж шалгахад эвдрэл гарсан бүх цэгт нөхөөс хийгдэж, Нарлаг хорооллын /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ар/ замд хийгдсэн нөхөөснүүд нягтрал муутай, цөмөрч эвдэрсэн, бусад замын засварт эвдрэл гэмтэл гараагүй байна.

Энэ нь зорчих хэсгийн орчин нөхцөлийг сайжруулсан, зам тээврийн осол гарах болон авто машины эвдрэл үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд сайн нөлөө үзүүлсэн ажил болсон байна.

Захиалагч тендерийг 9 дүгээр сард зарлан, тендерт шалгарсан байгууллагатай 10 дугаар сарын 18-ны өдөр ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, гэрээнд тусгаснаар ажлыг 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-нд ашиглалтад оруулахаар заажээ.

Нарлаг хорооллын /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ар/ замын чанар хангалтгүй хийгдсэн нь тухайн засварын ажлыг 10 дугаар сарын сүүлээр буюу агаарын хэм -5 градус, замын гадаргуугийн хэм -8 градус болсон үед гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Дэд бүтцийн хөгжлийн яамны сайдын 2000 оны 199 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам барих" нормын 701 дүгээр бүлгийн 701.3.А.3-д *"битумтэй хольцыг дэвсэхэд тавигдах дулааны хэмийн хязгаар хучилтын үеүдийн зузаан 10 см- ээс бага үед агаарын хэм +5 градус, замын гадаргуугийн хэм +7 градустай"* байхаар заасан байна.

Гэвч замын ажлын нормыг зөрчиж 701 дүгээр бүлгийн 701.03.А.1-д *"Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж битумтэй хольцыг зохих ёсоор дэвсэж ханатал нь нягтруулах боломжгүй байх буюу аливаа нойтон буюу хөлдүү гадаргууд дэвсэж болохгүй/* заасныг зөрчин ажлыг гүйцэтгүүлснээс ажил чанаргүй хийгдсэн байна.

Агаарын хэм хасах градустай улиралд тендерийг зарлаж, ажлыг гүйцэтгүүлсэн нь зохион байгуулалтын хувьд Дэд бүтцийн хөгжлийн яамны сайдын 2000 оны 199 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам барих" нормыг зөрчиж байна.

Цаашид сангийн хөрөнгөөр хийх зам барих, авто замын урсгал болон ээлжит засварын ажлыг хууль журмаар тогтоосон цаг хугацаанд хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөж, ажлыг норм, дүрмийн дагуу чанартай гүйцэтгүүлж сангийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж ажиллах шаардлагатай байна.

Зураг 1



Зураг 2



Зураг 1 Худалдааны гудамж, Цоглог дэлгүүрийн хойд талын зам

Зураг 2 Нарлаг хорооллын /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хойд талын зам/

Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажлыг "ХБХДТ" ХХК-ний боловсруулсан зураг, төсвийн дагуу "Баянгийн говь" ХХК гүйцэтгэжээ.

Ажлын чанарын хувьд явган хүний зам, авто зогсоолыг төсөвт тусгагдсаны дагуу орон нутгийн байгалийн чулуугаар шигтгэж гүйцэтгэсэн бөгөөд ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл гараагүй байв.

Мөн тус ажлын төсөвт тусгагдаагүй ургамлын хөрсийг хуулж зөөсөн, багсармал хольцон дээр суулгасан байгалийн чулууг шингэн зуурмаг хийж чулууг чигжиж өгсөн зэрэг зайлшгүй хийгдэх ажлуудыг өөрийн санаачилгаар, барилгын норм дүрмийн дагуу, төсөвт тохируулан гүйцэтгэсэн нь замын чанар, ашиглалтын хугацааг нэмэгдүүлсэн байна.

Тус ажил нь Их газрын чулууны ууланд хийгдэх баяр наадам болон бусад үед иргэд, жуулчдын тав тухтай байдлыг хангахад зориулагдсан ажлын нэг болжээ.

Зураг 3



Зураг 4



Зураг 3 Их газрын чулууны уулын задгай театраас авто зогсоол хүртэлх явган зам

Зураг 4 Их газрын чулууны уулын задгай театрын авто зогсоол

**БҮЛЭГ 3 АВТО ЗАМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ, ЗАРИМ АЖЛЫН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

### **3.1 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.**

Авто замын сангийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

2016 онд авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудын хяналтын зардалд нийт 2.9 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Ажил тус бүрээр Хавсралт 3-аар харууллаа.

Аймгийн зам засварын ажилд ГХБХБГ болон аймгийн ХОХБТ-ийн хэлтсээс хяналтыг хийсэн байна.

ГХБХБГ-аас ажлын явцад 3 удаа хяналтыг хийсэн бөгөөд тухай бүр үүрэг даалгавар өгч ажиллажээ.

"Их газрын чулууны Задгай театрын тохижилтын ажил"-ын хувьд аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/185 дугаар захирамжаар эрх



шилжүүлэн ажил гүйцэтгүүлж, хяналтыг ХОХБТ-ийн хэлтэс болон СТС-ийн хэлтэст даалгажээ.

Захилагчийн хяналтын зардал 1.4 сая төгрөгийг аймгийн Техник хяналтын сангийн дансанд шилжүүлсэн боловч зохих албад хяналтыг хийгээгүй, зардлыг жилийн эцэст орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлжээ.

Гурвансайхан сумын Засаг дарга болон холбогдох албан тушаалтнууд ажлын гүйцэтгэлд хяналтыг тавьсан гэх боловч хяналтын тайлан, нотлох баримт байсангүй.

Тус сум 2016 онд Их газрын чулуунд Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэж буй тохижилтын ажлаас гадна ОНХС-ийн хөрөнгөөр 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудад хяналт хийх /7 удаа/ явцад тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан талаар сумын санхүүгийн албаны дарга Ү.Алимаа тайлбар өгөв.

Аймгийн Засаг даргын зохих албад /*аймгийн ГХБХБГ-ын БХБ-ын хэлтэс/* хяналт хийгээгүй нь Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 5.19<sup>21</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна.

Тус ажлын зураг төсөвт технологийн дагуу зайлшгүй хийх шаардлагатай хөрс хуулалтын ажлыг оруулаагүй, ГХБХБГ-аас зураг төсөвт хяналт хийгээгүй учир гүйцэтгэсэн ажил батлагдсан тоо хэмжээнээс зөрүүтэй хийгджээ.

Мөн барилга байгууламжийн ажлыг хүлээн авсан тухай хурлын тэмдэглэлд гүйцэтгэсэн ажлын талбайн хэмжилт болон хөрс хуулалтын ажлын талаар тусгаагүй нь ажил хүлээн авах комисс хяналт тавьж ажиллаагүйг илтгэж байна.

### **3.2 Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн оруулж, олон нийтэд мэдээлсэн байна.**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Авто замын сангийн 2016 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулжээ. ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д Авто замын сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээг ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэхээр журамлаж өгсөн. Журмын хэрэгжилтэд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба улирал бүр хяналт тавьж, 2016 оны 3 дугаар улирлын байдлаар төлөвлөгөөт шалгалт хийжээ. Мөн аймгийн Аудитын газраас ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2016 оны 1, 3 дугаар улирлын байдлаар “Шилэн дансны

---

<sup>21</sup> Улсын замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг Авто замын газар, түүний зохих албад, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын зохих албад хариуцан хэрэгжүүлнэ

тухай хуулийн хэрэгжилт”-д 2 удаа нийцлийн аудит хийгдсэн нь мэдээллийг хууль, журмын дагуу бүрэн байршуулахад нөлөөлсөн байна.

## Ä-ÄÍ ÝËÒ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Авто замын сангийн орлогыг дутуу төлөвлөж, ИТХ сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлаагүй байна.
2. Авто замын тухай хуульд заасан эх үүсвэрийн 14.2 хувь буюу 33.0 сая төгрөгийг Авто замын санд төвлөрүүлээгүй байна.
3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж зорилтот үр дүндээ хүрчээ.
4. Зарим ажлыг хэрэгжих боломжгүй цаг хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн нь тендер шалгаруулалтын аргыг буруу сонгоход хүргэсэн байна
5. “Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил”-ын хяналтын төсөвт тусгагдаагүй боловч технологийн дагуу зайлшгүй хийгдсэн ажлыг гэрээнд нэмэлтээр тусгаагүй байна.
6. “Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилт”-ын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд тухайн салбарын талаар мэдлэг туршлагатай, мэргэжлийн зүгээс хяналт тавих төлөөллийг оролцуулаагүй байна.
7. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, төсөл арга хэмжээ нь зорилтот үр дүндээ хүрчээ.
8. Авто замын сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, зарим ажлын захиалагчийн хяналт хангалтгүй байна.
9. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн оруулж, олон нийтэд мэдээлсэн байна.

**ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**Аймгийн ИТХ-ын даргад**

1. Авто замын сангийн төсвийг батлахдаа сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хамт батлах;

**Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:**

2. Орон нутгийн зам ашигласны хураамжийн орлогыг орон нутгийн замын санд төвлөрүүлж зориулалтын дагуу зарцуулах;
3. Авто зам засварын ажлыг хэрэгжүүлэх боломжтой цаг хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөх;
4. Сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ны тендер шалгаруулалтын аргыг ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу сонгож зохион байгуулах;
5. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад тухайн ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан бол хуулийн дагуу шийдвэрлэж тухайн өөрчлөлтийг гэрээнд нэмэлтээр тусгаж байх;
6. Аймаг, суманд хийгдэж байгаа авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар /*аймгийн ГХБХБГ-ын БХБ-ын хэлтэс*/ гүйцэтгүүлж байх;
7. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын шинээр ашиглалтад оруулах комисст тухай салбарын төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохих хяналтыг хийлгэж, төсөл, арга хэмжээг хүлээн авч байх;
8. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд аймгийн ХОХБТ-ийн хэлтэс болон СТС-ийн хэлтсийн хяналтыг тогтмолжуулж хууль журамд нийцсэн, гэрээний шаардлагыг хангасан ажлыг санхүүжүүлэх;

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ХЯНАСАН : АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

## ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ажил хариуцсан холбогдох хүмүүст танилцуулж санал тайлбарыг авлаа.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,  
Утас: 7059-2494, Факс: 7059-2896,  
E-mail: info@dundgovi.gov.mn

2017.07.27 № 4/780  
танай 2017.07.24-ны № 141 -т

Г АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Г

Танай ирүүлсэн тайлантай танилцан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тухайн тайлангаа холбогдох газарт хүргүүлэн саналыг авах

2. 2016 онд 1 зөвлөх, 3 ажил хийгдсэн. Уг 3 ажлын 2 дээр ГХБХБГ-тай хамтран хяналтыг сайн тавьсан. 1 зөвлөх үйлчилгээний ажил дээр Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Хот тохижуулах газрын дарга, ГХБХБГ-ын БХБХэлтсийн дарга нартай хамтран газар дээр нь 3 удаа очиж, саналаа өгсөн. Иймээс хяналтыг хангалтгүй гэж үзэх үндэслэлгүй байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА *Сүрэн* Н.ЭРДЭНЭ-ОЧИР



*Усбаагийн  
Сүрэн, тасгийн дарга  
0370620-127*

## АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-т заасны дагуу аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

**Дундговь аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн санал, тайлбарт өгөх Аудитын газрын тайлбар**

<p style="text-align: center;"><b>Тайлбар 1</b></p>	<p>“2016 онд 1 зөвлөх, 3 ажил хийгдсэн. Уг 3 ажлын 2 ажил дээр ГХБХБГ-тай хамтран хяналтыг сайн тавьсан. 1 Зөвлөх үйлчилгээний ажил дээр Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Хот тохижуулах газрын дарга, ГХБХБГ-ын БХБ-ын хэлтсийн дарга нартай хамтран газар дээр нь 3 удаа очиж, саналаа өгсөн. Иймээс хяналтыг хангалтгүй гэж үзэх үндэслэлгүй байна.” гэсэн саналыг хүлээн авч тайлангийн 3 дугаар бүлгийн дүгнэлтийг хэсгийг “Авто замын сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, зарим ажлын захиалагчийн хяналт хангалтгүй байна.” гэж өөрчлөн найрууллаа.</p>
<p style="text-align: center;"><b>Санал 1</b></p>	<p>Аймгийн засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн харьяа хэлтэс агентлагуудад үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг шалгаж ажиллах эрх, үүрэгтэй тул бид аудитын тайлангийн төсөлд санал тайлбар авахаар хүргүүлсэн билээ. Иймээс “Тухайн тайлангаа холбогдох газарт хүргүүлэн саналыг авах” гэсэн саналыг хүлээн авах боломжгүй.</p>

## ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/15

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалын хавсралтын 5 дугаар заалт, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУАГ-НАБ/2017/02-ГА/-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. "Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 10 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Ихбаяр/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

D:\office\tushaal\A4\abto.docx

Дундговь аймгийн Аудитын газрын  
тэргүүлэх аудиторын 2017 оны 7 дугаар сарын  
71 -ны өдрийн А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

### АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: ДУАГ-НАБ/2017/02-ГА

Аудитын нэр: “Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”

сая төгрөгөөр

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс			Үр өгөөжийн		
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн төвд хийгдсэн нийт 94,507,614.00 / Ерэн дөрвөн сая таван зуун долоон мянга зургаан зуун арван дөрвөн/ төгрөгийн төсөвт өртөгтэй авто зам засварын ажлыг байршлаар нь 2 хэсэг болгон хувааж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй, харьцуулалтын аргыг сонгон тендер шалгаруулалт явуулсан	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн, 8.1-д /Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно/, 8.4-т / Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно/, 8.5-д /Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно/, 8.6-д / Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно/, 11.2-т /Захиалагч	94.5			1		1	94.5

		техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авахыг хориглоно/, 33 дугаар зүйлийн 33.1-д / Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т / Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох/, 24 дүгээр зүйлийн 24.4-т /Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно/							
2	Авто замын сангийн төсвийг батлахдаа сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлаагүй;	Засгийн газрын 1998 оны "Журам батлах тухай" 149 дүгээр тогтоолын 1.8 / Улсын замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, зарцуулах хөрөнгийн хэмжээг Засгийн газар, орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус батална/	179.8				1	1	179.8
3	Орон нутгийн зам ашигласны хураамжийн орлогыг орон нутгийн замын санд төвлөрүүлээгүй.	Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 /Замын сангийн эх үүсвэр хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн зам ашигласны төлбөр/					1	1	
4	Авто зам засварын ажлыг 10 дугаар сард буюу агаарын хэм -5 градус, замын гадаргуугийн хэм -8 градус болсон үед гүйцэтгэсэн.	Дэд бүтцийн хөгжлийн яамны сайдын 2000 оны 199 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам барих" нормын 701 дүгээр бүлгийн 701.03.А.1-д /Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж битумтэй хольцыг зохих ёсоор дэвсэж ханатал нь нягтруулах боломжгүй байх буюу аливаа нойтон буюу хөлдүү гадаргууд дэвсэж болохгүй/					1	1	
5	Гүйцэтгэгч байгууллага хяналтын төсөвт тусгагдаагүй, технологийн дагуу зайлшгүй хийгдсэн ажлын гүйцэтгэлийг гарган баталгаажуулж,	Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.14 /Аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгоно/					1	1	



	зардлыг санхүүжүүлэх акт үйлдсэн боловч ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулах, нэмэлт ажил гүйцэтгэх талаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй.								
6	Гурвансайхан суманд хийгдсэн Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажлын хяналтыг мэргэжлийн бус байгууллагаар хийлгэсэн, шинээр ашиглалтанд оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн салбарын талаар мэдлэг туршлагатай, мэргэжлийн зүгээс хяналт тавих төлөөллийг оролцуулаагүй;	Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.3 /Барилга байгууламжийн зориулалт, онцлогоос хамааруулан тухайн барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, техник технологитой нь холбоотой салбарын төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг комиссын бүрэлдэхүүнд оруулна/  Засгийн газрын 1998 оны “Журам батлах тухай” 149 дүгээр тогтоолын 1.8 /Улсын замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг Авто замын газар, түүний зохих албад, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын зохих албад хариуцан хэрэгжүүлнэ/					1	1	
7	Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо аймгийн ХОХБТ-ийн хэлтэс болон СТС-ийн хэлтэс хяналтыг хангалтгүй тавьсан.	Засгийн газрын 1998 оны “Журам батлах тухай” 149 дүгээр тогтоолын 1.8 /Улсын замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг Авто замын газар, түүний зохих албад, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын зохих албад хариуцан хэрэгжүүлнэ/					1	1	
Нийт дүн						1	6	7	274.3

## ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

## Авто замын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авах ажиллагаанд мөрдөгдсөн журам			Тендерт зарцуулсан хугацаа					Тендер /сая төгрөг/		Тендерийн хэмнэлт
			Нээлттэй	Тендер шалгаруулалтын онцгой журам		Үнэлгээний хороо байгуулсан огноо	Тендерийн урилга нийтэлсэн огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Зарцуулсан нийт хугацаа (хоног)	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөг	Шалгарсан өртөг		
				Хязгаарлагдмал	Харьцуулалт							Шууд гэрээ	
А	1	2	3	4	5	6	7	8	9	10=7+8+9	11	12	13=11-12
1	ДУХАА/2016/029	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажил			Харьцуулалт		2016.09.27	2016.09.29	2016.10.18	22	42.0	41.4	0.6
2	ДУХАА/2016/014	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил			Харьцуулалт		2016.09.27	2016.09.29	2016.10.18	22	53.7	53.1	0.6
3	ГСХАА/2016/ХА-02	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил			Харьцуулалт		2016.05.23	2016.06.06.	2016.06.23	52	79.8	79.3	0.5
4	ГСХАА/2016/ХА-03	Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил				Шууд гэрээ					6.0	6.0	-
<b>Дүн</b>											<b>181.5</b>	<b>179.8</b>	<b>1.7</b>

Хавсралт №2

## Авто замын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээний биелэлт, гүйцэтгэлийн судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр	Тендерийн ерөнхий мэдээлэл					Хугацаа хэтрүүлсэнд тооцсон алдангийн хэмжээ	Хэрэгжсэн	Хэрэгжилт дутуу	Хэрэгжээгүй	Тайлбар (дутуу болон хэрэгжээгүй бол шалтгаан, бусад тайлбар)
				Эхлэх	Дуусах	Сунгасан гэрээний дуусах огноо	Улсын комисс хүлээн авсан огноо	Хэтэрсэн хугацаа (хоног)					
				Огноо	Огноо								
A	2		4	7	8	9	10	11	12	13	14	15	16
1	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажил	53.1	"Бумбат даваа" ХХК	2016.10.20	2016.11.10		2016.11.02			Ажлыг зураг төсвийн дагуу бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгсөн			
2	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил	41.4	"Бумбат даваа" ХХК	2016.10.20	2016.11.10		2016.11.02						
3	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил	79.3	"Баянгийн говь" ХХК	2016.07.01	2016.08.16	2016.10.03							
4	Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил	6.0	"ХБХДТ" ХХК								Зураг, төсөв хийгдсэн.		Зураг, төсөв нь хийгдсэн боловч, ажил гүйцэтгэх гэрээ, зураг, төсөв хүлээн авсан акт нотлох баримт байхгүй
		<b>179.8</b>											

## Хавсралт №3

**Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээнд  
тусгасан төсвийн судалгаа**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээнд тусгасан төсөв / сая төгрөг/					Гэрээний нийт дүн
		Зам засварын ажил	Захиалагчийн хяналт	Зураг төсөв	Магадлашгүй ажил	Норм норматив	
1	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажил	38.5	0.6	1.5	0.7	0.06	41.4
2	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил	50	0.8	1.5	0.9	0.08	53.1
3	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил	76.5	1.4		1.4		79.3
4	Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил			6.0			6.0
	<b>Дүн</b>	<b>164.8</b>	<b>2.8</b>	<b>9.0</b>	<b>3.0</b>	<b>0.1</b>	<b>179.7</b>

## Хавсралт №4

Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл  
арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээнд заасан хугацаа			Улсын комисс хүлээн авсан огноо	Тайлбар
		Эхлэх	Дуусах	Сунгасан гэрээний дуусах огноо		
		Огноо	Огноо			
1	Буянт гүүр, найрамдал, зоо, Айргийн гудамжийн авто замын засварын ажил	2016.10.20	2016.11.10		2016.11.02	Ажлыг зураг төсвийн дагуу чанартай, хугацаанд нь бүрэн гүйцэтгэсэн тул хүлээн авсан.
2	Буян нэмэх, Бага тойруу, Худалдааны гудамжийн авто замын засварын ажил	2016.10.20	2016.11.10		2016.11.02	
3	Их газрын чулууны уулын Задгай театрын тохижилтын ажил	2016.07.01	2016.08.16	2016.10.03	2016.10.03	Ажлын явц 90 хувьтай байхад урьдчилгаа болон гүйцэтгэлийн санхүүжилт хийгдээгүй шалтгаанаар хугацааг сунгаж ажлыг төсвийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн тул хүлээн авсан.
4	Хүүхдийн паркийн авто замын дагуух 2.1 км явган хүний замын зураг төсөв хийх ажил					Зураг, төсөв хийлгэх ажилд 4.2 сая төгрөг зарцуулсан боловч, ажил гүйцэтгэх гэрээ, зураг, төсөв хүлээн авсан акт нотлох баримт байхгүй